



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данс бүртгэлээс хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон 224,430,749.82 (хоёр зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун дөчин есөн төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг данс бүртгэлээс хасахыг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, Увс аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Улаанхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 99 дүгээр тогтоолын хавсралтын 4 дүгээр хэсгийг хүчингүйд тооцсугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ 300491

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 19 ны өдрийн
309 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар	Ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Лексус LX 570, 00-99 ОРО	2019	224,430,749.82
Нийт дүн			224,430,749.82
			(хоёр зуун хорин дөрвөн сая дөрвөн зуун гучин мянга долоон зуун дөчин есөн төгрөг наян хоёр мөнгө)